


“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН



УЛААНБААТАР ХОТ

2022 ОНЫ 06 САР



ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны 3-р сарын 23-ны өдөр шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржийн зүгээс 2022 оны 6-р сарын 9-ний өдөр үнэлгээний аргачлалыг боловсруулсан.

Энэхүү үнэлгээний аргачлалын дагуу Богд банк ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хийж гүйцэтгэсэн бөгөөд үр дүнг ТУЗ-ийн гишүүдэд танилцуулан, саналыгтусгасны үндсэн дээр ТУЗ-ийн дарга хянаж баталсан болно.

ҮНЭЛГЭЭНИЙ АСУУЛГЫН БҮТЭЦ

1. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт
2. ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг
3. Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал
4. Аудит, хяналтын тогтолцоо
5. Эрсдэлийн удирдлага
6. Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал
7. Оролцогч талуудын эрх ашиг
8. Компанийн соёл
9. Хувьцаа эзэмшигчдийн эрх гэсэн 9 үндсэн үзүүлэлт бүхий нийт 36 асуулгаас бүрдсэн.

ҮНЭЛГЭЭНИЙ ОНОО

Асуулга тус бүрийн хүрээнд хийгдвэл зохих ажлын хэрэгжилтийг 0-2 оноогоор үнэлж түүнийгээ хувьд шилжүүлэн, үнэлгээг 0-100 хувиарт тооцож гаргасан болно.

- Бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2 оноо;
- Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан бол 1 оноо;
- Хэрэгжүүлээгүй, үнэлгээ ирүүлээгүй бол 0 оноо.

НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ

Үнэлгээний нэгдсэн дунд үндэслэн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ.

- Авбал зохих нийтоооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй
- 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул Монголын хөрөнгийн биржээс зөвлөмж хүргүүлэх;
- 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул Монголын хөрөнгийн биржээс зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэйтүл зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай гэж үзнэ.



БОГД БАНК ХК-ИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 06 сарын 20-ны өдөр

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АСУУЛГА

Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол ягаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана.

НЭГ ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна

№	ЗҮЙЛ	ХЭРЭГЖИЛТ	ТАЙЛБАР
1	1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Эдгээр албан тушаалтны хариуцах ажлын чиг үүрэг, хариуцлагыг журамд хариуцах ажлынх нь төрлөөр ангилан нэлээд дэлгэрэнгүй тусгасан. Харин тэдгээрийн ханиуцлагын талаар энэ оны 3 дугаар улиралд багтаан бага зэрэг нэмэлт оруулна
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна	Хэсэгчилэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд нарийвчлан тусгасан байгаа. Харин тэдгээрийн залгамж халааны бодлогын баримт бичгийг энэ оны 3дугаар улиралд боловсруулан батлуулахаар ажиллаж байгаа
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайландаа дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандaa байршуулна.	Хэсэгчилэн хэрэгжүүлсэн	Бүх мэдээллийг вэб сайтанд тусгасан.



№	ЗҮЙЛ	ХЭРЭГЖИЛТ	ТАЙЛБАР
4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	Ихэнх нь хэрэгжсэн	Хороодын ажиллах тусгайлсан нэгдсэн журамтай бөгөөд түүнд гишүүдийг сонгох, чөлөөлөх болон гишүүдийн эрх, үүргийг тусгаснаас гадана хороо бүрийн чиг үүрэг, хорооны хурлыг хуралдуулах журам зэргийг тусгасан. Цаашид нэгдсэн журмаа хороо бүрээр салган энэ асуулгад заасан зарим дутуу зүйлээ тусган шинэчлэхээр ажиллаж байгаа болно
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Хэрэгжүүлж эхлэхээр ажиллаж байгаа	Энэ асуулгад дурдсан асуудлаар тусгайлсан журам боловсруулахаар ажиллаж байгаа болно залгамж халааны бодлогын баримт бичгийг энэ оны Здугаар улиралд боловсруулан батлуулахаар ажиллаж байгаа
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Бүрэн хэрэгжүүлдэг	ТУЗ-ийн НБД-ийн томилгоо болон үйл ажиллагааг түүний хэрэгжүүлэх ёстой ажлынх нь төрлөөр ангилан ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгайлан зааж өгсөн болно



ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ

ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ

№	ЗҮЙЛ	ХЭРЭГЖИЛТ	ТАЙЛБАР
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Хуульд заасны дагуу хэрэгжсэн	Цаашид энэ асуулгад заасны дагуу болгохоор ажиллаж байгаа болно.
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцно.	Хэсэгчлэн хэрэгжсэн	Аудитын хорооны дарга нь хараат бус гишүүн хэрэгжүүлдэг Аудитын хорооны үйл ажиллагааг хороодын нэгдсэн журмаар зохицуулдаг. Цаашид хорооны тусгайлсан журамтай болохоор ажиллаж байна.
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцно.	Хэсэгчлэн хэрэгжсэн	Цалин урамшууллын хорооны даргын албан тушаалыг хараат бус гишүүн хэрэгжүүлдэг. Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааг хороодын нэгдсэн журмаар зохицуулдаг. Цаашид хорооны тусгайлсан журамтай болохоор ажиллаж байна.
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Хэсэгчлэн хэрэгжсэн	Нэр дэвшүүлэх хорооны даргын албан тушаалыг хараат бус гишүүн хэрэгжүүлдэг. Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааг хороодын нэгдсэн журмаар зохицуулдаг. Цаашид хорооны тусгайлсан журамтай болох, мөн залгамж халааны бодлогын баримт бичигтэй болохоор ажиллаж байна.
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Хэсэгчлэн хэрэгжсэн	Манай компани хуульд заавал байхаар заасан 3 хороотойгоос гадна байнгийн ажиллагаатай эрсдэлийн хороог байгуулан ажиллуулдаг. Мөн шаардлагатай тохиолдолд байнгийн болон түр хороог байгуулж болох болон хорооны гишүүдэд тавих шаардлагыг тусгасан заалтыг журамдаа оруулахаар ажиллаж байна.



ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана

№	ЗҮЙЛ	ХЭРЭГЖИЛТ	ТАЙЛБАР
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн	Тусгайлсан журам байхгүй. Компанийн дүрэмд энэ талаар зарим нэг заалт байгаа. Цаашид тусгайлсан журам боловсруулах ажлыг эхлүүлж энэ оны 3 дугаар улиралд багтаан ил тод байдал, тайлагналтын журмыг боловсруулан батлуулж хэрэгжилтэнд нь хяналт тавих ажлыг хэрэгжүүлэхээр ажлыг эхлүүлсэн болно.
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн	Кодекст заасан дүрэм, журмуудаас одоо байгааг нь шинэчлэн сайжруулах, байхгүйг нь шинээр боловсруулах ажлын энэ оны 3 дугаар улирлаас эхлүүэх зорилгоор мэргэжлийн экспертийг гэрээний үндсэн дээр ажлуулж байна.
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Бүрэн хэрэгжилж байгаа	Санхүүгийн болон ESG-ийн тайлагналтай холбогдуулан GRI-ийн нарийн бичгийн дарга нарын газраас санхүүгийн компаниудад зориулан гаргасан тайлагналтын стандартын хүрээнд мэдээлэх ёстой мэдээллийн жагсаалтыг уг мэдээллийг гаргах албан тушаалтны хамт гаргах ажлыг эхүүлсэн болно



ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана

№	ЗҮЙЛ	ХЭРЭГЖИЛТ	ТАЙЛБАР
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлж эхэлсэн	Хороодын ажиллах нэгдсэн журмын аудитын хорооны чиг үүргэгт хөндлөнгийн аудиттой харьцах зарим асуудлыг тусгасан байгаа. Цаашид аудитын хорооны ажиллах тусгайлсан журмын төслийг боловсруулж түүнд энэхүү асуулгад заасан асуудлыг тусган хэрэгжүүлэхээр ажлыг эхлүүлээд байна.
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Хэрэгжээгүй	Энэ асуултанд заасан асуудлыг аудитын хорооны үйл ажиллагааны болон ХЭХ-ын журамд тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар ажлыг эхлүүлж байна
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Хэсэгчлэн хэрэгжиж байгаа	Компанийн зохион байгуулалтын бүтцэд дотоод хяналтын нэгж ажилладаг бөгөөд түүний үйл ажиллагааг зохицуулсан тусгайлсан журамтай. Цаашид түүний бүтэц зохион байгуулалт, үйл ажилалгааны тайланг энэхүү асуулгын хүрээнд нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах болно.



ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина

№	ЗҮЙЛ	ХЭРЭГЖИЛТ	ТАЙЛБАР
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Бүрэн хэрэгжиж байгаа	Компани нь ТУЗ-ийнхээ дэргэд эрсдэлийн удирдлагын хороо ажилладаг бөгөөд түүний үйл ажилалгааг хороодын ажиллах нэгдсэн журмаар зохицуулдаг. Мөн Гүйцэтгэх удирдлагын хүрээнд эрдэлийн удирдлагын нэгж ажилладаг бөгөөд түүний үйл ажиллагааг уг хэлтэсийн үйл ажиллагааны журам болон Эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлого зэрэг баримт бичгийн хүрээнд зохицуулдаг. Цаашид Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны тусгайлсан журамтай болгож түүнд компанийн эрсдэлийн удирдлагад хяналт тавих асуудлыг тусган хэрэгжүүлэхээр ажлыг эхлүүлээд байна.
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	Бүрэн хэрэгжиж байгаа	Компани нь ТУЗ-ийнхээ дэргэд эрсдэлийн удирдлагын хороо ажилладаг бөгөөд түүний үйл ажилалгааг хороодын ажиллах нэгдсэн журмаар зохицуулдаг. Цаашид эрсдэлийн хорооны тусгайлсан журамтай болж, түүнийг хорооны бүтэц бүрэлдэхүүний хамт цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлдэг болохоор ажиллаж байгаа болно
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Хэсэгчлэн хэрэгжиж байгаа	ESG-ийн тайлагналтанд хамрагдах асуудлын талаар компани дээр үүсч болзошгүй эрсдэлийг үнэлэх аргачлалыг боловсруулж мөрдөх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.



№	ЗҮЙЛ	ХЭРЭГЖИЛТ	ТАЙЛБАР
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Бүрэн хэрэгжиж байгаа	Компани комплайнсын хэлтэстэй бөгөд уг хэлтэс өөрийн үйл ажиллагааны журамтай бөгөөд түүнд заасан заалтын дагуу үйл ажилалгаагаа явуулдаг.



ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ

Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна

№	ЗҮЙЛ	ХЭРЭГЖИЛТ	ТАЙЛБАР
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Бүрэн хэрэгжүүлдэг	ТУЗ-ийн гишүүдийн цалингийн төсвийг жил бүр ХЭЭХ-аар хэлэлцэн батладаг. Цаашид цалинг олгох хэлбэр давтамжийг тусгасан журам гаргахаар эхлэн ажилалж байгаа болно.
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Хэсэгчлэн хэрэгжиж байгаа	Одоо компанийн хэмжээнд эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын асуудлыг ТУЗ-ийн ажиллах журамд заасны дагуу хэрэгжүүлж байгаа бөгөөд цаашдаа энэ асуулгад заасан асуудлыг тухайн ажилтны асуудлыг тусгасан бодлогын баримт бичигт тусгах ажлыг эхлүүлээд байна.
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Тодорхой ажил хийгдээгүй байгаа	Цаашид энэхүү асуулгад заасан асуултыг тусгасан журам боловсруулахаар ажиллаж байгаа болно

ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ

Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ

№	ЗҮЙЛ	ХЭРЭГЖИЛТ	ТАЙЛБАР
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Хэсэгчлэн хэрэгждэг	Компани дүрэмд тус асуудлыг оруулсан байгаа. Цаашид энэхүү асуулга заасан асуудлаар бодлогын баримт бичиг боловсруулахаар төлөвлөн ажиллаж байгаа болно
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Энэ асуудлаар тодорхой зүйлийг тайланд тусгаагүй байгаа	IPO төлөвлөгөөнд тусгагдсан байгаа. Цаашид дэлгэрэнгүй тайланд тусгахаар төлөвлөж байгаа
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Хэрэгжиж байгаа	Цахим хуудсанд байнга шинэгчлэгдэж байгаа бүхээгдэхүүн үйлчигээний талаар мэддээлэл хүргэж байгаа.
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Хэрэгжүүлсэн сайжруулах	Компанийн Хөдөлмөрийн дотоод дүрэм журманд тусгагдсан цаашид илүү дэлгэрэнгүй сайжруулах шаардлагатай

НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ

ТУЗ-ийн гишүүд компанийд бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно

№	ЗҮЙЛ	ХЭРЭГЖИЛТ	ТАЙЛБАР
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлж эхэлсэн	Компанийн дүрэм болон ТУЗ-н үйл ажиллагааны дүрэм журманд тусгагдсан. Хяналтын механизмыг илүү нарийвчлан тусгах шаардлагатай
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	Бүрэн хэрэгжүүлж эхэлсэн	Богд банкны Ёс зүйн дүрэмд ажилтан бүр шүгэл үлээгчийн үүрэгтэй байх талаар тусгасан ба зөрчлийг мэдээлэх суваг, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон байгаа. Цаашид хяналтын механизмыг илүү сайжруулна.
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Хэрэгжүүлж эхэлсэн	. Энэ талаар тусгасан төстэй заалтууд зарим журамд бий. Холбогдох журамд нарийвчлан дэлгэрэнгүй тусгах шаардлагатай



ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана

№	ЗҮЙЛ	ХЭРЭГЖИЛТ	ТАЙЛБАР
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Хэрэгжүүлж эхэлсэн	Цахим хуудсанд мэдээлэл тогтмол байршдаг
33	8.2. Аливаа хуул 9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ. бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	Тодорхой ажил хийгдээгүй байгаа	Банкны цахим хуудас болон хөрөнгийн биржийг сайтад хөрөнгө оруулагч наарт зориулсан мэдээ мэдээлэлийг оруулж байгаа.
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Хэрэгжүүлсэн	Хуульд заасны дагуу хурлын саналыг авдаг хурлыг зохион байгуулдаг.
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Хэрэгжүүлж эхэлсэн	Хууль болон дүрэм журмыг дагаж мөрдэн ажиллаж байна
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Хэсэгчлэн хэрэгжиж байгаа	Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдэж холбогдох тогтоол шийдвэрийг гаргадаг. Хэлцлийг батлахад ТУЗ-ийн хараат бус гишүүд заавал оролцдог.